

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕС ДЭХ УДААГИЙН СОНГУУЛИАР БАЙГУУЛАГДСАН  
УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5 - 11
1. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал	6 - 9
2. Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал	10 - 11

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн  
анхдугаар чуулганы Хууль зүйн байнгын хорооны  
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 05 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Д.Ганбат, М.Нарантуяа-Нара, Б.Тулга;*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв.

***Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг нэр дэвшүүлж байгааг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны даргад нэр дэвшигч Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан шинээр суурилуулсан тоног төхөөрөмж, программ хангамж хангалттай ажиллахгүй байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.4-т заасны дагуу “санал хураалтыг гар өргөж явуулья” гэсэн горимын саналыг гаргав.

**Б.Дэлгэрсайхан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	0
Бүгд:	15

100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Дэлгэрсайхан:** Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 0  
Бүгд: 15  
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 05 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Хоёр.Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

**Б.Дэлгэрсайхан:** Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг, О.Номинчимэг, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар, М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 0  
Бүгд: 15  
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 05 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 19 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 05 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Б.ДЭЛГЭРСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
05 цаг 08 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Дэлгэрсайхан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Баасанжаргал, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Борхүүгийн Дэлгэрсайхан, Лхагвын Мөнхбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Дамдины Цогтбаатар, Жадамбын Энхбаяр гэсэн.

Өөр үлдсэн хүн байна уу? Байхгүй байна уу?

Ирц бүрдсэн байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Б.Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Баярлалаа.

Дэгийн тухай хуулийн дагуу санал хэлэх эрхтэй учраас Хууль зүйн байнгын хороонд нэг санал хэлчхээд гарах гэсэн юм.

Санал хураалгаж өгөөрэй гэж хүсэж байна.

Хууль зүйн байнгын хорооны харьяанд Хүний эрхийн дэд хороо гэж байгаа.

Хүний эрхийн дэд хороонд Хууль зүйн байнгын хороонд манай намаас байгаа М.Нарантуяа-Нараг Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулж өгөхийг хүсээд, мөн эрх барьж байгаа буюу засагт оролцож байгаа сайд нь Ардчилсан намаас байгаа учраас Хүний эрхийн дэд хорооны даргад М.Нарантуяа-Нараг нэр дэвшүүлж байна.

Тэгээд энэ бол даруухан амбиц. Дээрээс нь зөв байх тухай асуудал учраас энэ тал дээр санал хураалгаж өгөөрэй гэж хүсье.

Тэгээд өөр Байнгын хороонд бас ирц дугаж байгаа учраас ингээд гараад саналаа өгчихсөн учраас болно. Тийм ээ. Баярлалаа.

**Б.Дэлгэрсайхан:** Бүрэлдэхүүнд  
М.Нарантуяа-Нара гишүүнийг  
оруулчихсан байгаа.

Даргын тухай асуудал бол  
дараагийн хуралдаанаар яригдах учраас

энэ тухай бол одоо яригдахгүй ээ гэдгийг  
албан ёсоор хэлье.

Өөр саналтай гишүүн байна уу?  
Байхгүй. Тийм ээ. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орё.

---

### Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

---

Байнгын хорооны даргыг сонгох  
тухай асуудлыг хэлэлцье.

Байнгын хорооны даргад нэр  
дэвшигчийг Улсын Их Хурал дахь  
Монгол Ардын намын бүлгийн дарга  
Лхагвын Мөнхбаатар танилцуулна.

**Л.Мөнхбаатар:** Байнгын  
хорооны гишүүдийн амрыг эрье.

Нэр дэвшүүлэх асуудлыг  
танилцуулъя.

Монгол Ардын намын бүлгийн  
зүгээс Хууль зүйн байнгын хорооны  
даргад Улсын Их Хурлын гишүүн  
Дамдины Цогтбаатарыг нэр дэвшүүлж  
байна.

Д.Цогтбаатар гишүүний намтрыг  
уншиж танилцуулъя.

Дамдины Цогтбаатар 1970 онд  
Улаанбаатар хотод төрсөн.

Эхнэр, 2 хүүхдийн хамт  
амьдардаг.

Англи, орос, кхмер, тай, герман  
хэлний мэдлэгтэй.

1988 онд Монгол, Оросын  
хамтарсан 14 дүгээр сургууль, 1994 онд  
Оросын Холбооны Улсын Москва хотын  
Олон улсын харилцааны дээд сургуулийг  
улс төр судлалын мэргэжлээр, 1998 онд  
Австралийн Холбооны Улсын Үндэсний  
их сургуулийг олон улсын хуульч  
мэргэжлээр тус тус төгссөн.

1994-2002 онд Гадаад хэргийн  
яаманд ажилтан, 2002-2008 онд Монгол  
Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын  
зөвлөх, 2008-2011 онд Гадаад  
харилцааны яамны Төрийн нарийн  
бичгийн дарга, 2011-2012 онд Монгол  
Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2012 онд  
Засгийн газрын гишүүн, Байгаль орчин,  
аялал жуулчлалын сайд, 2014-2015 онд  
Засгийн газрын гишүүн, Барилга, хот  
байгуулалтын сайд, 2016-2020 онд  
Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-  
2018 онд Хүний эрхийн дэд хорооны  
дарга, 2017-2020 онд Засгийн газрын  
гишүүн, Гадаад харилцааны сайд, 2020-  
2024 онд Монгол Улсын Их Хурлын  
гишүүн, 2023-2024 онд Монгол Улсын  
Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны  
дарга, 2024 оноос Улсын Их Хурлын  
гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж  
байна.

Улсын Их Хурлын гишүүн  
Дамдины Цогтбаатарыг Улсын Их

Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Эрхэм гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

**Б.Дэлгэрсайхан:** Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудалд өөр саналтай гишүүд байна уу?

Нэр дэвшигчээс асуулт асуух гишүүн байна уу? Х.Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Нэр дэвшигчээс гурван асуулт байна.

Өмнө нь Хууль зүйн байнгын хороон дээр Ц.Мөнх-Оргил гишүүн ахалж байсан уу? Тийм.

Өмнөх Хууль зүйн байнгын хороон дээрээс нэг ажлын хэсэг байгуулаад Ц.Мөнх-Оргил гишүүн ахлаад Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжтой холбоотой нэг юм явж байсан. Тийм.

Тэр Үндсэн хуулийн цэцтэй холбоотой хууль тогтоомжийг одоо цааш нь үргэлжлүүлэх сонирхол байгаа юу, үгүй юу? Нэг. Эхний асуулт нь.

Хоёрт нь, ер нь манай парламентад Хууль зүйн байнгын хорооны чиг үүрэг дээр их том алдаа байгаа.

Би чуулган дээр бас хэлсэн.

Манайд Хүний эрхийн дэд хороо гээд нэг дэд хороотой. Түүндээ бид маш их чухал ач холбогдол өгдөг.

Гэтэл ер нь улс орнуудын Хууль зүйн байнгын хороо чинь хүний эрх гэхээсээ илүүтэй иргэнийхээ үндсэн эрхийг хэрэгжүүлэх талаар эхэлж анхаарч ажиллаж байгаа шүү дээ. Үндсэн суурь зарчим нь.

Тэгээд иргэний үндсэн эрхтэйгээ холбоотой зөрчлүүдийг, эсвэл Хууль зүйн байнгын хороонд харьяалагдаж байгаа Дотоод хэргийн яам, Хууль зүйн яам, АТГ гэх мэтчилэн Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө рүү халдаж ордог эрхтэй, гүйцэтгэх ажил явуулдаг, барьж хорьдог гэх мэтчилэн ийм байгууллагуудыгаа шалгахын тулд ийм ерөнхий нэртэй Хүний эрхийн дэд хороо биш. Бүр яг зорилготой цагдаагийн дэд хороо, тэрний дэд хороо, энэний дэд хороо гэж тийм дэд хороогоор нэртэйгээр ажилладаг юм билээ. Бусад улс орнуудад бол.

Тэгээд энэ жоохон сул байгаа, алдаатай байгаа энэ нөхцөл байдлаа засах тийм хүсэл эрмэлзэл, хувийн итгэл үнэмшил байх болов уу, яах бол гэж хоёр дахь асуултаа асуумаар байгаа юм.

Гуравт нь, бүр хамгийн ноцтой нь манай Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд харьяалагддаг Тусгай хяналтын дэд хороо гэдэг институц байгаа.

Бусад улс оронд харахаар үүнийгээ хоёр хуваачихдаг юм билээ.

Цэрэг, тагнуул хоёроо тусад нь гаргачихдаг юм билээ.



Түүнээс бусад одоо яг цагдаагийн байгууллага юм уу. Одоо манай дээр Авлигатай тэмцэх газар юм уу, эсвэл тагнуулын мөрдөн шалгах чиг үүрэг бүхий гэдэг ч юм уу.

Энэ байгууллагуудын гүйцэтгэх ажилтай холбоотой. Ер нь гүйцэтгэх ажил гэдэг ийм нэртэй хууль ч бусад улс оронд байхгүй.

Шүүхийн зөвшөөрөлтэй эсвэл далд мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой. Үүнийх нь төсөв мөнгийг нь хянадаг, явуулсан үйл ажиллагааг нь хянадаг, иргэний үндсэн эрх, энэ хүрээнд нь зөрчигдсөн үү, үгүй юу гэдгийг хянадаг тийм Тусгай хяналтын дэд хороо шиг хороог Хууль зүйн байнгын хороон дээр байгуулах тийм хүсэл эрмэлзэл бас төрөх болов уу, үгүй юу гэж ийм гурван асуултыг асуух гээд байгаа юм.

Хууль зүйн яам аль намд очсоноос үл шалтгаалаад парламент Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа ийм институцүүдийг бүрэн хянах чадвартай байх ёстой.

**Б.Дэлгэрсайхан:** Д.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Д.Цогтбаатар:** Үндсэн хуулийн тэр цэцтэй холбогдолтой хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал орж ирж байсан. Ажлын хэсэг байгуулагдаж байсан.

Би бараг өөрөө санал гаргаад өөрийн чинь ажлын хэсэгт нь оруулъя гэдэг нэг яриа явж байгаа. Тэгээд орсон. Тийм ээ. Харин тийм.

Тэгээд миний түүн дээр гаргаж тавьж байсан нэг л асуудал байгаа.

Юу гэвэл Дээд шүүхээр гүйцэд шийдэгдээд дуусчихсан асуудлыг үндсэн эрхийн асуудлаар гээд Үндсэн хуулийн цэц дээр авч хэлэлцэх энэ үүд хаалгыг нээх гэж байсан.

Энэ дээр би жинхэнээсээ болгоомжилж байсан. Энэ чинь ингээд зөв үү?

Яагаад гэвэл яг түүн дээрээ тулбал үндсэн эрхтэй хамаагүй.

Ямар ч сайн өмгөөлөгч бол аливаа нэгэн эргэлзээтэй клиентийг авлаа гэхэд, үйлчлүүлэгчийг авлаа гэхэд би хэргээ хэзээ ч Дээд шүүх дээр дуусгахгүй Үндсэн хуулийн цэц дээр аваачиж дуусгана гэдэг л шууд юутай явна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр энэ дээр цаанаасаа бүүр ийм суурь том өөрчлөлт гарах юм биш биз дээ. Үүнийгээ та нар судалж үзээрэй гээд. Тэгээд ажлын дэд хэсэг дээр ярьж байгаад эцсийн гүйцэд шийдэл гаргалгүй тэндээ үлдээсэн байгаа.

Буцаагаад сөхөөд аваад үүнийг үзэж болно.

Гэхдээ миний тэр асуулт бол нээлттэй хэвээрээ л үлдэж байгаа.

Энэ иргэдийн үндсэн эрхийн асуудал Хүний эрхийн дэд хороо байгаа.

Түүний хажуугаар цагдаагийн дэд хороо эд нар байгуулж болох уу гээд.

Би бол нээлттэй. Үүнийг бол ёстой хэрэв ажилд хэрэгтэй, хамгийн гол нь хүний эрхэд хэрэгтэй байгаа бол бид явж болохгүй зай, хийж болохгүй ажил гэж байхгүй. Тэрийг л хийх ёстой.

Тэгэхээр түүн дээр дутагдал байгаа бол би үүнийг нээлттэй ярьж үзэж, судалж үзэхэд бэлэн.

Энэ Тусгай хяналтын дэд хорооны тухайд гэвэл нэг ийм л асуудал байгаа.

Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо гэдэг чинь зөвхөн гадаад бодлого биш аюулгүй байдлын асуудал гэдгээрээ дотоод асуудлууд бас орчхоод байгаа юм.

Жишээлбэл, Батлан хамгаалах яамны асуудлууд.

Энэ чинь Гадаад яам биш шүү дээ. Манай цэвэр дотоодын батлан хамгаалахын асуудлууд бол энэ Байнгын хороогоор орж байдаг.

Тэгэхээр тэр “аюулгүй байдал” гэдэг үгний шапо үгийнхээ дотор энэ Тусгай хяналтын дэд хорооны үйл ажиллагаанууд орчихсон байдаг гэж би ойлгодог.

Өнөөдрийг хүртэл яваад ирчихсэн уламжлал маань ийм байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр миний хувьд одоо бол би шууд ингээд газар дээрээ тийм ийм гэж бол хэлж мэдэхгүй байна.

Үүнийг та үндэслэлийг нь гаргаад ийм ийм байгаа. Дотоодын энэ асуудал бол Хууль зүйн байнгын хороон дээр байх ёстой гэвэл хэдүүлээ нээлттэй үүнийг ярьж болно.

**Б.Дэлгэрсайхан:** Асууж асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Горимын санал гаргана. Санал хураах төхөөрөмж сааталтай байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын саналаар санал хураалт явуулъя гэж санал гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дугаар зүйл санал хураалтыг цахимаар, эсвэл гар өргөж нууц санал хураалтыг цахимаар, эсвэл санал хураалтын хуудсаар явуулна.

10.4-д санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна гэсэн байна.

Тэгээд горимын санал гаргах хүн байна уу? Би өөрөө гаргах юм уу?

Гар өргөж санал хураалт явуулъя гэсэн горимын санал байна.

Горимын саналыг 100 хувь дэмжиж байгаа учраас Дамдины Цогтбаатарыг Хууль зүйн байнгын хорооны даргаар дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. /алх цохив/

Байнгын хорооны даргыг 100 хувийн саналаар дэмжиж сонгосон тул хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулна.

Дараагийн хоёр дахь асуудал.

## Хоёр.Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал

Хоёр дахь асуудал. Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.3.3-д “дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тогтоол батална” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд Байнгын хорооны бүрэлдэхүүнд байгуулах дэд хорооны асуудлыг зохицуулсан бөгөөд Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнд Хүний эрхийн дэд хороог байгуулахаар заасан.

Үүний дагуу Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.” гэж заасныг баримтлан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг болон бусад Байнгын хорооны

гишүүдийн саналыг үндэслэн Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд:

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нарыг оруулахаар танилцуулж байна.

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Улсын

Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжжэ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг илээр гар өргөөд 100 хувийн санал хураалтаар бүрэлдэхүүнийг томиллоо.

Улсын Их Хурлын гишүүний Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулна.

Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа Та бүхэнд. /алх цохив/

Хуралдаан 19 минут үргэлжилж, 05 цаг 27 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**